# УБ хот БГДүүрэг 20-р хороонд үйл ажиллагаа явуулж буй ТӨМӨР БЕТОН ЭДЛЭЛИЙН ҮЙЛДВЭР-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.

БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР БҮХИЙ ТӨМӨР БЕТОН ЭДЛЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР МҮ-4.1.1

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 6542522 /

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга:

_______________________________/________________________________/

Хянасан: Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн:

_______________________________ /______________________/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: АРГА ХИЙЦ ОД ХХК-ийн захирал

_______________________________ / Т.АРИУНЖАРГАЛ /

Биелэлтийг тайлагнасан: АРГА ХИЙЦ ОД ХХК-ийн байгаль орчны хэлтсийн мэргэжилтэн

____________________________ / Л.ГАНЗОРИГ /

2024 он

Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Байршил

1.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

2.1 Тоосжилт

2.2.1 Тоос дарах зорилгоор технологийн хаягдал усыг дахин ашиглах,

2.2.2 Төлөвлөгөөний хэрэгжилт, замын арчилгаа, усалгаа

2.2.3 Автомашины хурдны хязгаар зохион байгуулалт

2.2.4 Тоосонцорын агууламжийн хэмжилт түүний чанарын шинжилгээ

2.2 Агаар

2.2.1 Агаарын чанарын шинжилгээ

2.3 Цэвэр ус ашиглах дүгнэлт, түүний гэрээ

2.3.1 Цэвэр усны чанарын шинжилгээ

2.4 Бохир ус цэвэрлэх байгууламж

2.4.1 Бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир усны хяналт шинжилгээ

2.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

2.5.1 Хатуу ба шингэн хог хаягдал

2.6 Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа

3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

3.1 Хөрс

3.2 Төслийн талбайг тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах

3.3 Орчныг цэвэр байлгах талаар хороотой хамтран ажиллах, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах

4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

5. Талуудад тайлагнах төлөвлөгөө

6. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт. Контор

6.1. Бомт-ний зардал.

6.2. Бомт-ний биелэлтийн дүн.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“АРГА ХИЙЦ ОД” хязгаарлагдмал хариуцлагатай компани нь Нийслэлийн БГДүүргийн нутаг дэвсгэрт байрлах “БАЙГУУЛАМЖ ОД” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн охин компанийн хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр үүсэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, өөрийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгж юм.

Төслийн талбай нь Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт, тус дүүргийн Засаг даргын 2021 оны 11 сарын 22-ны өдрийн А/514 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 1681910209 дугаар бүхий 7874*м2* газрыг үйлдвэрийн газрын зориулалтаар 13 жилийн хугацаатай эзэмшихээр эрх авсан. Бетон зуурмагийн үйлдвэр нь 1 цагт 30*м3* үйлдвэрлэх хүчин чадалтай хятад улсад үйлдвэрлэсэн бүрэн автомат үйлдвэр. Бетон эдлэлийн үйлдвэрлэлийн технологийн үндсэн зарчим нь суурин стендийн арга болно. Хэвлэх цех дэх технологийн шугам нь БНХАУ болон БНСУ-д үйлдвэрлэсэн техник тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон бөгөөд зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдлаас хамаарч жилд дунджаар 7500*м3,* сард дунджаар 800*м3* орчим бетон зуурмаг болон төмөрбетон эдлэл үйлдвэрлэж байна. Төслийн хүрээнд нийт 29 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

“Арга хийц Од” ХХК нь 2020 оноос хойш тасралтгүй Төмөрбетон эдлэлийн үйлдвэрийн чиглэлээрээ дагнан ажиллаж байна. Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох бетон зуурмагаа өөрийн бетон зуурмагийн үйлдвэрээс шууд нийлүүлдэг.

Үйлдвэрийн үндсэн хэсгүүд:

1. Арматур бэлтгэлийн хэсэг
2. Үйлдвэрлэлийн хэсэг
3. Дулааны боловсруулалтын хэсэг
4. Бэлэн бүтээгдэхүүний талбай
5. Бетон зуурмагийн узель гэсэн үндсэн 5 хэсэгээс бүрдэнэ.



## 1.1 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төсөл хэрэгжүүлж буй Төмөрбетон эдлэлийн үйлдвэр нь БГДүүрэгт байрлах ДЦС-IV зүүн талд үйлдвэрийн бүсэд байрладаг.



## 1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Бид Байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2023 онд "ЭХМОНГОЛЫН БАЙГАЛЬ" ХХК-ААР гүйцэтгүүлэн БОАЖЯамаар батлуулан таван жилийн хугацаатай БОМТөлөвлөгөө боловсруулан байгаль орчны асуудлуудтай холбогдож болзошгүй болон, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. АРГА ХИЙЦ ОД ХХК нь төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээд болохын хувьд "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", Монгол улсын хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнахад тус тайлангийн зорилго оршино. Тус компани нь үйлдвэрийн үйл ажиллагаа явагдаж буй орчинд байгаль орчны зохистой менежментийг бий болгох зорилгоор байгаль орчныг хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Хог хаягдалын менежментийг зохион байгуулах
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх



## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.1 Тоосжилт

| № | Арга хэмжээ | Хэрэгжилтийн товч тодорхойлолт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|
| 1. | Үйлдвэрийн тоосжилт бууруулах усалгаа, чийгшүүлэлт хийх. | Мехнизмийн хөдөлгөөн хийгддэг хэсгүүд дээр чийгшүүлэлтийн ажил хийгдсэн. | 100% |
| 2. | Үйлдвэрийн тоос болон тоосонцорын үзүүлэлтүүдийн түвшинг сонгосон цэгүүд дээр хэмжилт хийнэ. | Бетон зуурмагийн талбай, үйлдвэрлэлийн талбай, гадна орц гарц буюу оффисын гадна талбай гээд нийт 3 цэгт багаж ашиглан хэмжилтийг хийсэн. | 100% |
| 3. | Үйлдвэрийн хашаанд нэвтрэх том оврын машины хурдны хязгаар тогтоох | Цемент, элс хайрга, бүтээгдэхүүн тээвэрлэх том оврын авто машинуудад хаалт хийж орох бүрт харуулын албаныхан сануулга анхааруулгыг өгч хурдны хязгаарыг тогтоож өгсөн. | 100% |

2.1.1 Бид цаг уурын нөхцөлөөс хамаарч хууршил ихтэй чийг багассан тоосорхог өдрүүдэд үйлдвэрийн хашаандах тоосжилтийг бууруулахаар бетон зуурмагийн үзель болон миксер машин цэвэрлэсэн усыг дахин ашиглах зорилгоор тус хаягдал усыг хоёр дахин шүүн тунгааж ашигладаг. Ингэснээр ажилчдын эрүүл мэндийн байдалд эерэгээр нөлөөлөх буюу ойр очмын тоосжилтыг бууруулж байна.

Дахин ашиглагдаж буй усыг ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ-аар 2024 оны 10 сарын 09-ны өдөр MNS ISO стандартын дагуу шинжилгээний аргын сорьц авхуулан туршилтыг хийлгэсэн.

/Баталгаажуулах зураг болон Сорилт шинжилгээний үр дүнг хавсаргав. **Дугаар он/№ 2024/Б-205/**





### 2.1.2 Тоосонцорын агууламжийн хэмжилт

Тоосны агууламжийн хэмжилтийг БОМТөлөвлөгөөнд тусгагдасны дагуу ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ-аар 2024 оны 10 сарын 08-ны өдрийн 09:30 минутаас 10:30 минутын хооронд үйлдвэрийн хашаанд гурван цэгт шинжилгээний аргын стандартын дагуу сорц авхуулан туршилтыг хийлгэсэн.

Агаарын чанарын MNS 4585:2016 стандартын /20 минутын хэмжилт/

| № | Сорьц авсан цэг | Арматур, үйлдвэрийн талбайн орчим | Зуурмагийн үзелийн орчим | Оффис, гадна үүдний орчим |
|---|---|---|---|---|
| 1 | Нийт тоос /TSP/ | 0.066 | 0.04 | 0.094 |
| 2 | Агаарын чанарын стандарт /MNS 4585:2016/ | 0.500 | | |

Туршилтын дүнгээс харахад үйлдвэрийн талбайн тоосжилтын хэмжээ нь стандартын шаардлага хангаж байгаа гэж үзэж байна. Манай компани нь дараа жилүүдийн төлөвлөгөөнд үйлдвэрийн хашаандах авто замтай хэсгүүдийг хатуу хучилттай болгохоор төлөвлөж байгаа.

Бетон зуурмаг хэсэг



Оффис болон үүдний хэсэг



Арматур болон үйлдвэрийн талбайн хэсэг





### 2.1.3 Үйлдвэрийн хашаанд нэвтрэх том оврын машины хурдны хязгаар тогтоох

Төсөл явагдаж байгаа хашаа нь төв замаас шууд нэвтрэх боломжтой учир том оврын машинууд үйлдвэрийн хашаанд мөрдөгдөх хурдны хягаарыг давсан хурдтайгаар нэвтрэн орж ирж хөрсний сулрал, тоосжилтыг нэмэгдүүлдэг байсан учир бид гадна хашааны хаалгандаа автомат хаалтыг суулгаж өгснөөр харуул хамгаалтын албаны заавар зөвөлгөөний дагуу орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж заасан хурд тогтоосон зогсоолын цэгт тээврийн хэрэгсэлээ байрлуулах болсон нь илүү хөдөлгөөнийг хязгарлаж хөрсний сулрал болоод тоосжилтыг багасгаж чадсан.




### 2.2 Агаарын чанарын мониторинг

Тоосны агууламжийн хэмжилтийг БОМТөлөвлөгөөнд тусгагдасны дагуу ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ-аар 2024 оны 10 сарын 08-ны өдрийн 09:30 минутаас 10:30 минутын хооронд үйлдвэрийн хашаанд гурван цэгт шинжилгээний аргын стандартын дагуу сорьц авхуулан туршилтыг хийлгэсэн.

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м3 | | | ДБА |
| 1 | Бетон зуурмаг хэсэг | X/08 | 09:30 | 0.010 | 0.047 | 0.066 | 54 |
| 2 | Зуурмагийн үзель орчим | X/08 | 10:00 | 0.015 | 0.044 | 0.040 | 51 |
| 3 | Оффис, гадна үүд | X/08 | 10:30 | 0.009 | 0.034 | 0.094 | 48 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 | | | | 0.450 | 0.200 | 0.500 | 60 |

/Сорилт шинжилгээний үр дүнг хавсаргав. **Дугаар он/№ 2024/А-279/**

### 2.3 Цэвэр усны дүгнэлт шинжиилгээ

Манай компани нь улиралын чанартай ажилдаг тул жил бүрийн эхний улиралд багтаан МУЗГазрын хэрэгжүүлэгч агентлаг УСНЫ ГАЗАР-аас ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан гэрээ хийж баталгаат тоолуураар зөвшөөрлийн дагуу цэвэр ус ашиглаж төлбөр тооцоог цаг хугацаанд нь барагдуулан дуусгадаг.

/Ус ашиглуулах дүгнэлт, гэрээг хавсаргав. /

**Цэвэр усны шинжилгээ.**

2024 оны 09 сарын 13 өдөр НАРТ ШУУН КОНСАЛТИНГ ХХК хөрсний итгэмжлэгдсэн лабораторт цэвэр усны шинжилгээ өгч шинжлүүлэхэд химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцын бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандартын шаардлага хангасан гэж гарсан.

/Сорилт шинжилгээний үр дүнг хавсаргав. **Дугаар № 24/09-19/**


"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

№ 24/09-19

Захиалагч: "Арга хийц од" ХХК
Дээж авсан цэг: БГД 20 хороо, Үйлдвэрийн гудамж ГЭЦ-4 зүүн тала
Сорьц авсан огноо: 2024 оны 09 сар 13 өдөр
Усны төрөл: худгийн ус
Аргын стандарт: MNS1097:1970

| Катион | мг/л | мг-экв/л | мг-экв% | Анион | мг/л | мг-экв/л | мг-экв% |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Ca^{++}$ | 90.00 | 4.49 | 76.74 | $CO_3^{-}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 12.00 | 0.99 | 16.87 | $HCO_3$ | 160.00 | 2.62 | 44.83 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | $Cl^{-}$ | 41.00 | 1.16 | 19.77 |
| $K^{+}$ | 1.00 | 0.03 | 0.44 | $SO_4^{-}$ | 87.00 | 1.81 | 30.99 |
| $Na^{+}$ | 8.00 | 0.35 | 5.95 | $NO_3^{-}$ | 16.00 | 0.26 | 4.41 |
| Дүн | 111.00 | 5.85 | 100.00 | Дүн | 304.00 | 5.85 | 100.00 |

Анион катионуудын нийлбэр
Σ 415 мг/л
HCO₃-ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: 335 мг/л
Физик үзүүлэлтүүд
Өнгө: 0-өнгөгүй,
Үнэр: 0-үнэргүй
Булингар: Булингаргүй
Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 260 ppm
Ерөнхий хатуулаг: 5.48 мг-экв/л
бага хатуулагтай ус
Урвалын орчин: pH- 7.29
Цахилгаан дамжуулах чадвар
EC -0.649 ds/m
TDS 357 ppm

$$M(0.42)=\frac{HCO3\ 45\ SO4\ 31\ [Cl\ 20]}{Ca\ 77\ [Mg\ 17\ Na\ 6]}$$

*Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.*

"Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018" - стандартын шаардлагыг хангаж байна.

[illegible]

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Т.СОЛОНГО Ph.D, Дэд проф


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2024.04.30 № 01/556
таны 2024.03.14-ны № 04/177-т

"АРГА ХИЙЦ ОД" ХХК-Д

Танай байгууллагын 2024 оны А.08/2024 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Туул голын сав газраас шилжүүлсэн албан бичиг, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжиж байгаа "Төмөр бетон эдлэл" үйлдвэрлэлийн төсөлд 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.
Хувийг: Туул голын сав газрын захиргаанд
Хавсралт: 4 хуудастай.

Иргэдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалья, хуримтлуулья, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

162430940

## 2.4 Бохир ус цэвэрлэх байгууламж

Манай компаний ойролцоо төвийн бохир залуулах шугам байхгүйн улмаас бид гурван тунгаагуууртай цэвэрлэх байгууламжыг хийж ашиглалтанд оруулсан байгаа. Тус цэвэрлэх байгууламжийн бохир усыг бид ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ-аар 2024 оны 10 сарын 09-ны өдөр шинжилгээний аргын стандартын дагуу шинжилгээ хийлгэсэн.





### 2.4.1 Бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир усны хяналт шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024 / Б-205
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Арга хийц Од" ХХК, 99763067
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Б.Дөлгөөн, БОХЗТЛ
Сорьцын тоо,төрөл : 1, бохир ус
Сорьц авсан огноо : 2024.10.09
Сорьцын тодорхойлолт : Бохир усны сорьц
Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001, MNS 6836:2020, MNS ISO 6060:2001, MNS ISO 5815-1:2015, MNS 1097:2023, MNS 6779:2019, MNS 6834:2020, MNS ISO 6878:2001
Шинжилсэн огноо : 2024.10.09-2024.10.21
Хуудасны тоо : 1 /1
Үр дүн : 1

| Сорьц авсан цэг | pH | Жб мг/л | ХХХ мг/л | $БХХ_5$ мг/л | $NH_4$ мг/л | $NO_2$ мг/л | $NO_3$ мг/л | $N_{нийт}$ мг/л | $P_{эрд}$ мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БГД, 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс Эрчим хүчний гудамж-292 тоот | 12.27 | 32.1 | 86.0 | 47.1 | 0.32 | 0.052 | 11.4 | 2.85 | 0.004 |
| **MNS 6561:2015** | **6.0-9.0** | **400** | **800** | **400** | **15** | - | - | **30** | **5** |

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ХХХ- Химийн Хэрэгцээт Хүчилтөрөгч, $БХХ_5$- Биохимийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: А.Цолмонбаяр
Шалгасан шинжээч: Б.Анужин
Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: С.Отгонжаргал

## 2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 2.5.1 Хатуу ба шингэн хог хаягдал

**Ахуйн, Үйлдвэрийн хог**

Хот тохижилтын газартай хамтран жил бүр гэрээ байгуулан ахуйн болон үйлдвэрийн зориулалттай хог хаягдалыг ангилан МОРИН ТХЦэгт гэрээт хөлсний машинаар тээвэрлэн хаядаг.



**ХОГ ХАЯГДАЛ ХАЯХ ГЭРЭЭ**

2023 оны 05 дугаар сарын 08 №23/86 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /цаашид "А" гэх/ түүнийг төлөөлж газрын дарга Б.Мөнхцэцэг, нөгөө талаас "Арга хийц од" ХХК РД:6542522 /цаашид "Б" гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Т.Ариунжаргал /хамтад нь "талууд" гэх/ нар Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 109-р тогтоол, Хот тохижилтын газрын 2016 оны дүрэм, 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам зэргийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Үндсэн нөхцөл**

1.1 Б тал нь Баянгол дүүргийн 20 дугаар хороо үйлдвэрийн баруун бүсийн Арга хийцод ХХК-ы үйлдвэрлэлээс гарсан /зуурмагийн машин угаасан лаг/ хог хаягдлыг **HOWO** маркийн **55-10 УНЯ, HOWO** маркийн **46-96 УНА** улсын дугаар бүхий автомашинаар тээвэрлэн Хан-Уул дүүргийн Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт хаях хог хаягдалыг А талын пүүнд хэмжилт хийж, баримт үйлдсэнд үндэслэн ландфиллийн ажлын хөлсийг Б тал нь гэрээнд заасан хугацаанд нь төлөх санхүүгийн харилцааг зохицуулна.

**Хоёр. Төлбөр, тооцоо хийх журам**

2.1 Нэг тонн хог хаягдлын үнэлгээ: **4350** */дөрвөн мянга гурван зуун тавь /*төгрөг байна. НӨАТ шингэсэн үнэ болно.

2.2 Зориулалтын цэгт хог хаягдал хаях үеийн нийт тонн, хэмжээний төлбөрийг сар бүрийн 30-ны өдрөөр тооцоо нийлж, А талын **Хаан банкны 5064975024** тоот дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

2.3 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч А талын үнэ тарифт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

**Гурав. Гэрээний үйлчлэх хугацаа**

3.1 Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоов.

3.2 Гэрээ үйлчилж эхлэх хугацаа:2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байна.

3.3 Гэрээний дуусах хугацаа:2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.

**Дөрөв. Талуудын эрх, үүрэг**

4.1 Б тал нь хог хаягдалыг зориулалтын машинаар ачиж, тээвэрлэх

4.2 Б тал нь хог хаягдал тээвэрлүүлсэн төлбөрөө энэ гэрээний 2.2-т заасны дагуу хугацаанд нь бүрэн төлнө.

4.3 Б тал нь төлбөр төлөх үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцон тээвэрлэгч талд алданги төлнө. Нийт алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

4.4 Б тал нь тухайн хогийн цэгт ажиллаж буй А талын ажилчин, ажилтан нарын заавдын дагуу хог хаягдалаа буулгана.

8.3 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

**Ес. Маргаан шийдвэрлэх**

9.1 Энэхүү гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.2 Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад талуудын хооронд гарах аливаа асуудлыг албан бичгээр мэдэгдэнэ.

9.3 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар үүссэн маргааныг гэрээний үндсэн нөхцөл, агуулгад нийцүүлж талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөөнд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Арван. Бусад заалт**

10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсноор гэрээ дуусгавар болно.

10.2 Гэрээг шинэчлэх, сунгах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

10.3 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.4 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **А талыг төлөөлж** | **Б талыг төлөөлж** |
| --- | --- |
| "ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.МӨНХЦЭЦЭГ | "АРГА ХИЙЦ ОД" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.АРИУНЖАРГАЛ |
| САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ М.ОЮУНСҮРЭН | ҮЙЛДВЭРИЙН ДАРГА Л.ГАНЗОРИГ |
| САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН НЯГТЛАН БОДОГЧ Ж.ДААРИЙМАА | |
| Хаяг: Баянзүрх дүүргийн 1 хороо, Залуусын гудамж, Сансар тунель дээрх өөрийн байр | Хаяг: Баянгол дүүргийн 20 хороо, Үйлдвэрийн баруун бүс,Өөрийн байр |
| Утас: 11- 453501 | Утас: 99904954,99039731 |



**Шингэн хог хаягдал.**

Бетон зуурмагийн үйлдвэрийн зуурмагийн тогоо, миксер машин угаасан усыг тунгаан шүүж цэвэршүүлэн хашааны тоосжилт ихтэй газруудыг услах чийгшүүлэх байдлаар дахин ашигладаг.









2025 онд тоосруулагч насос ашиглан автоматжуулах төлөвлөгөөтэй байгаа.

### 2.6 Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа

Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх авто машин, механизмын техникийн хэвийн ажиллагааг болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах.

Манай компани нь өөрийн эзэмшилийн 44-84ҮНҮ суудлын авто машин, 83-47УБА портер 83-40 УБА миксер, 05-05УН ковш болон тоног төхөөрөмжинд хуваарьт үзлэгийн дагуу жил бүрийн 5 болон 9 сард шаардлагатай үйлчилгээ болон тос тосолгоог тогтмол хийдэг. Техник бүрийн техникийн паспортыг тус бүрт нь тэмдэглэл хийн баталгаажуулдаг.












## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.1 Хөрс.

Хөрсөн бүрхэвчийн шинжилгээг БОМТөлөвлөгөөнд тусгагдасны дагуу НАРТ ШУУН КОНСАЛТИНГ ХХК хөрсний итгэмжлэгдсэн лабораторт 2024 оны 09 сарын 13 өдөр шинжилгээний аргын стандартын дагуу хөрсний дээж өгч шинжлүүлсэн.



"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

**№ 24/09-18/1**

Захиалагч: **"Арга хийц од" ХХК**
Дээж авсан цэг: **БГД 20-р хороо, үйлдвэрийн гудамж ТЭЦ-4 зүүн талд**
Сорьц авсан огноо: **2024 оны 09 сар 13 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **09 сарын 18**
Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс. % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох сууриуд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| Дээж 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-20 | 7.20 | 0.011 | 0.026 | 0.53 | 0.00 | 0.09 | 7 | 9 | 1.9 | 2 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж 1 | | | | | | | | |
| 1 | 0-20 | 34.2 | 51.4 | 7.2 | 4.3 | 0.3 | 2.6 | 7.2 |

** Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд* MNS3310:1991, MNS ISO10390, *хөрсний механик бүрэлдэхүүн* MNS6824:2020)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.ҮҮГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

### 3.2 Төслийн талбайг тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах.

Манай компани нь 2024 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсны дагуу тэр бум мод төслийн хүрээнд 2023/10/14-ны өдөр Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 15ш модыг тарьсан. Ирэх жилийн төлөвлөгөөндөө өөрсдийн эзэмшлийн талбайд мод болон ногоон байгууламжийн ажлын төлөвлөгөөг тусгасан байгаа.






**Бид төслийн хашаанд тарьсан мод.**











**3.3 Орчныг цэвэр байлгах талаар хороотой хамтран ажиллах, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах.**

Үйлдвэрийн хашааний ойр орчмын зам талбай ногоон байгууламжийн хог хаяглыг хавар болон намрын улиралд 5 болон 10 сард цэвэрлэж хэвшсэн. Бусад хугацаанд бороо цас шавар шавхайтай үед тухай бүр нь нийтийн эзэмшилийн ойроцоох авто зам явган замыг цэвэрлэдэг.








## 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны ажил эхлэхтэй холбогдуулан ТӨГС БАЯН ХҮРЭЭ сургалтын байгууллагатай хамтран ХАБЭА-н хүрээнд гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтны аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлээс эрүүл мэндээ хамгаалах, хуулв эрх зүйн ойлголтыг өгөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулан шалгат авч баталгаажуулсан байгаа. Үүнд гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт багтсан болно.









Сертификат хавсаргав.

## 5. ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | Оршин суугч, оролцогч далууд | Тайлагнах хэлбэр | Мэдээний агуулга | Хугацаа | Зохион байгуулах газар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | БГД 20-р хорооний иргэд | Хийгдсэн ажлууд талагнах | БОрчны жилийн тайлан | 2024/11/22 | Өөрийн байр | Товлогдсон өдрөө тайлагнах |

## 6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь БОМТ–ний хэрэгжилтийн баталгааг бий болгож буй хэлбэр гэж үзэж ихээхэн ач холбогдол өгөх ёстой. БОМТ-ний хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус бусад алба, хэлтэс, нэгжийн ажилтнууд болоод гэрээт байгууллагын ажилтан, албан хаагч нарын оролцоо шаардагддаг. Тус дэд төлөвлөгөөгөөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтид оролцооны хэлбэрийг тодорхойлон хэрэгжилтийг хангах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Бид энэ таван жилийн хугацаанд ажилчдын байр, гал тогоо, конторын байшинг нэгтгэн 2 давхар 300м2 барилгыг барьж ашиглалтанд оруулсан маань ажилтан албан хаагчдын эрүүл ахуй, тав тухтай ажлын байраар хангаад зогсохгүй халуун хүйтэн ус, цэвэр бохир усны шийдлийг стандарт нормын дагуу хангаж өгсөн. Цаашлаад бид гадна тохижилт ногоон байгууламж хатуу хучилттай зам талбайг зургийн дагуу гүйцэтгэхээр ажиллаж байна.

Хуучин ажилчдын байр, галтогоо



Хуучин оффиын барилга



Шинээр баригдсан оффисын барилга




Гадна тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө.



## 6.1. БОМТ-НИЙ ЗАРДАЛ.

| д/д | Зардлын нэр төрөл | Албан байгуулга | нэгж | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Техникийн хэвийн ажиллагаа болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах. | АОДЭ ХХК<br>ЗЭС ГАЛ ХХК | Жилд 2 удаа | 1 797 000<br>253 000 |
| 2 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Цаг уур орчны шинжилгээний газар<br>Нарт ШУУН консалтинг ХХК | Жилд нэг удаа | 217 000<br><br>99 000 |
| 3 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | Баянгол цэцэрлэгт хүрээлэн<br>Бусад /өөрийн хашаанд/ | 15 мод<br>10 мод | 1 285 000<br>675 500 |
| 4 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Төгс баянхүрээ ХХК | 1 | 900 000 |
| 5 | Хог хаягдалын менежментийг зохион байгуулах | Морин ТХЦ<br>Онц тээвэрчин ХХК | 13<br>13 удаа тээвэр | 537 479<br>1 300 000 |
| 6 | Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах | Өөрийн байр | 1 | 1000000 |
| 7 | Нийт | | | 8 022 979 |

## 6.2. БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН.

| д/д | Арга хэмжээ | Биелэлт | Хувь, % |
|---|---|---|---|
| 1 | Техникийн хэвийн ажиллагаа болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах. | Шаардлагатай үйлчилгээ хийгдсэн | 100 |
| 2 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Бүх шинжилгээ хийгдсэн | 100 |
| 3 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | Тэр бум мод төслийн хүрээнд хийгдсэн | 95 |
| 4 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Сургалт хийсэн | 100 |
| 5 | Хог хаягдалын менежментийг зохион байгуулах | Журам мөрдөгдсөн | 100 |
| 6 | Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах | 11сард төлөвлөгдсөн байгаа | 90 |
| 7 | Дундаж хувь =97,5% | | |